

БАТЛАВ:
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.НАЦАГДОРЖ
2023 оны 04-р сарын 14-ны өдөр

192103/020 9023003

ДАРХАН-УС СУВАГ ХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ЭРДЭНЭБАТ

2023 оны 04-р сарын 14-ны өдөр

ДАРХАН-УС СУВАГ

ХК

2138042-401926701-1016314

ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1. Улсын онц чухал объектын хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, объектод хүн тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, аюулгүй байдлыг хангах ажиллагааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Энэ журмын 1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Дотоодын цэргийн тухай хууль, Байгууллагын стандарт /CS11-0129:2018/, дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм болон бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.
- 1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
“Улсын онц чухал объект”- Монгол Улсын Засгийн Газраас /цаашид “Засгийн газар” гэх/ тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг;
“Объектын хамгаалалт”- Улсын онц чухал объектын хэвийн үйл ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг;
“Байнгын үнэмлэх”-Тухайн объектын ажилтан, ажилчдад объектын захиргаанаас нэг жил буюу түүнээс дээш хугацаатай олгоно;
“Түр нэвтрэх үнэмлэх”- Ажлын зайлшгүй шаардлагаар гадны байгууллагаас ажил үйлчилгээ гүйцэтгэхээр ирсэн иргэнд объектын захиргаанаас нэг жил хүртэл хугацаагаар олгох бөгөөд иргэний үнэмлэх болон бусад гэрчлэх баримт бичгийн хамт хүчин төгөлдөр байна;
“Хүчинтэй баримт бичиг”- Хуулийн үйлчлэлийн хугацаандаа агуулга, бүрдэл хэсэг нь бүрэн баримт бичгийг хэлнэ.
“Хүчингүй баримт бичиг”- Хугацаа хэтэрсэн, агуулга өөрчлөгдсөн, хуулийн хүчингүй болсон баримт бичгийг хэлнэ.

Хоёр: Объектод хүн, эд зүйл шалган нэвтрүүлэх

- 2.1. Объектод хүн, тээврийн хэрэгсэл, бараа материалыг нэвтрүүлж, хяналт тавих, хүчин төгөлдөр бус болон баримт бичиггүй хүн, тээврийн хэрэгсэл, бараа материалыг нэвтрүүлэхгүй, аюулгүй байдлыг хангах зорилгоор харуулчин нь объектод нэвтрэх эрхийн баримт бичгийг шалгаж, хяналт тавина.
- 2.2. Улсын онц чухал объектод нэвтрэх эрхийн баримт бичгийг дараах төрөлтэй байна:
 - 2.2.1. Байнгын нэвтрэх үнэмлэх;

- 2.2.2. Түр нэвтрэх үнэмлэх;
- 2.2.3. нэг удаагийн үнэмлэх

- 2.3. Шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь хүний бичиг баримт, эд зүйлийг шалгахдаа дор дурдсан ажиллагааг хийсэн байна:
 - 2.3.1. Өөрийгөө танилцуулж, тухайн хүний ирсэн зорилгыг асууж тодруулсны дараа бичиг баримтаа шалгуулахыг хүсэх;
 - 2.3.2. Бичиг баримтыг шалгахдаа тухайн хүнээс бичиг баримтыг гар дээрээ авч, шалгуулагчаас 2-3 алхам хойш ухарч зай авсны дараа шалгах;
 - 2.3.3. Бичиг баримтаа шалгуулж байгаа хүний гадаад байдлын онцлогийг сайн ажиглаж, нүүрэн хэсгийн сорви, мэнгэ, шивээс, нүд, чих, хамрын хэлбэрийг ажиглан, зурагтай нь тулгаж харах;
 - 2.3.4. Шаардлагатай тохиолдолд бичиг баримтаа шалгуулан нэвтэрч байгаа хүний авч яваа цүнх, гар тээш овор ихтэй эд зүйлд үзлэг хийх.
- 2.4. Объектод нэвтрэх эрхийн бичиг баримтыг шалгах үед анхаарах зүйл:
 - 2.4.1. Объектод нэвтрэх эрхийн бичиг баримт /үнэмлэх/-ын ерөнхий байдал;
 - 2.4.2. Эзэмшигчийн гэрэл зураг;
 - 2.4.3. Олгосон болон хүчин төгөлдөр байх хугацаа, баталгаажуулалт;
 - 2.4.4. Чанар байдал /бичиг баримтын он, сар, өдөр, дугаар, тоо, үсгийг балласан, арилгасан, засварласан шинж тэмдэг байгаа эсэх/.
- 2.5. Дараах бичиг баримтыг шаардлага хангаж байгаа бичиг баримтад тооцно:
 - 2.5.1. Баримт бичиг эх загвартайгаа тохирсон;
 - 2.5.2. Хүчинтэй байх хугацаа дуусаагүй;
 - 2.5.3. Гэрэл зураг, тэмдэглэгээ, гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан;
 - 2.5.4. Төрөл бүрийн засвар хийгдээгүй;
 - 2.5.5. Үнэн зөв, алдаагүй бичигдсэн, эзэндээ олгогдсон нь нотлогдсон байх.
- 2.6. Шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, сэтгэцийн өвчтэй зэрэг сэжиг бүхий иргэний нэвтрэх эрхийн баримт бичгийг хураан авч, объектод нэвтрүүлэхгүй түр саатуулан эрх бүхий байгууллага /нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага гэх мэт/, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэж, хүлээлгэн өгнө.
- 2.7. Улсын онц чухал объектын шалган нэвтрүүлэх байраар нэвтэрч байгаа объектын ажилчид болон иргэд тээврийн хэрэгслээс бууж шалган нэвтрүүлэгч харуулчин нь журмын дагуу үнэмлэх бичиг баримтаа шалгуулж иргэдийн нэвтрэх хэсгээр объектод нэвтэрнэ.

Гурав: Объектын хамгаалалтад тээврийн хэрэгсэл, ачаа тээшийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлага

- 3.1. Тээврийн хэрэгсэл, ачаа тээшийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд ачаатай тээврийн хэрэгсэл шалгах зориулалтын тавцан, нүх, шөнийн цагт шалгалт хийх зориулалттай гэрэлтүүлэх хэрэгсэл, доод хэсгийг шалгах толь, метал илрүүлэгчээр хангаж, бусад шалгалтын багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглана.
- 3.2. Объектын хамгаалалтад тээврийн хэрэгсэл, ачаа тээшийг шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэх харуулчин нь дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ:

- 3.2.1.Объектод нэвтрэх тээврийн хэрэгслийн замын хуудас, дагалдах баримт бичиг /үнэмлэх/-ийг шалгаж, үзлэг хийх;
 - 3.2.2.Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхдээ тээврийн хэрэгслийг бүрэн зогсоож, гар тормозыг татуулж, хөдөлгүүрийг унтраалган, жолоочийг нь буулгаж, машины бүхээг, тэвш, тээшний хэсэг, дугуй, доод хэсэг шаардлагатай бол хөдөлгүүрийн хэсгийг шалгах;
 - 3.2.3.Битүүмжлэлтэй ачаа, тээш, чингэлэгний лац, ломбыг дагалдах баримт бичигтэй нь тулган үзэж, лац, ломбоны дардас нь дагалдах бичигтэйгээ тохирохгүй, дардаст өөрчлөлт орсон байвал объектын захиргаанд мэдэгдэж шалгуулах;
 - 3.2.4.Объектын ажилчдын хувийн тээврийн хэрэгслийг объектын захиргаанаас тогтоосон зогсоолд тавиулж, нэвтрэх эрхийн бичгийг нь шалгаж нэвтрүүлэх;
 - 3.2.5.Объектод нэвтрэх бичиг баримтын загвар, тамга, тэмдэг, гарын үсгийг тогтоох;
 - 3.2.6.Хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээшийг нэвтрүүлэхэд тогтоосон журмыг чанд сахиулах;
 - 3.2.7.Зөрчил гарсан үед хамгаалж байгаа объектод хүн, тээврийн хэрэгслийг зөвхөн салбарын захирагч, харуулын дарга нарын зөвшөөрлөөр нэвтрүүлэх;
 - 3.2.8.Нэвтэрч байгаа хүн нэг бүрийн бичиг баримтыг нарийвчлан шалгасны дараа нэвтрэхийг зөвшөөрөх;
 - 3.2.9.Нэг удаагийн нэвтрэх бичиг баримтыг шалгах үед бичиг баримтын хугацаа, олгосон албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг мөн эсэхийг магадлах, тэднийг объектоос гарах үед уулзсан албан тушаалтнаар нэвтрэх бичиг баримтад гарын үсэг зуруулсан эсэхийг шалгаж, хураан авах;
 - 3.2.10.Тээврийн хэрэгслийг шалгаж, үзлэг хийхдээ тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчидтой соёлтой харьцах, албаны үг хэллэгээр шаардлага тавих;
 - 3.2.11.Тээврийн хэрэгслийг “ЗОГС” тэмдэг бүхий шугаман дээр зогсоож, жолоочийг хөдөлгүүрээ унтрааж, бүрэн зогсолт хийсний дараа баримт бичгийг нь шалгах, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;
 - 3.2.12.Ачаа, тээшийг дагалдах бичиг баримтад заасан тоо хэмжээтэй нь тохирч байгааг шалгах;
 - 3.2.13.Тээврийн хэрэгслийг шалгах явцад зөрчил илэрвэл түр саатуулан, харуулын дарга /салбарын захирагч/-д нэн даруй илтгэх.
- 3.3. Объектод нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл, ачаа, тээшийг шалган нэвтрүүлэх үед анхаарах зүйл:
- 3.3.1.Албан үүргээ гүйцэтгэх үед бэртэх, гэмтэх, золгүй байдал учрахаас урьдчилан сэргийлэх;
 - 3.3.2.Хөдөлгөөнтэй үед төмөр зам дээр зогсох, явж байгаа тээврийн хэрэгслийн урдуур харайж гарах, тэрчлэн янз бүрийн тээврийн хэрэгсэл тэр тусмаа хүн тээхээр төхөөрөмжлөөгүй тээврийн хэрэгслээр явах;

- 3.3.3.Объектод нэвтэрч байгаа галт тэргийг шалгах үед тусгай шат хэрэглэх;
- 3.3.4.Тээврийн хэрэгсэл бүрэн зогсоогүй байхад түүнд ойртож болохгүй бөгөөд тээврийн хэрэгслийг зогсоохын тулд зам голлож зогсох, объектын хашааны хаалга, замын хаалтыг задгай орхихгүй;
- 3.3.5.Машиныг дур мэдэн жолоодож хөдөлгөх, машины бүхээгт сууж яваа хүмүүсийн баримт бичгийг шалгахдаа бүхээгний гишгүүр дээр зогсох, объектын хашааны хаалга, замын хаалтыг нээлттэй байхад машины ачаанд үзлэг хийхээр дугуйгаар дамжин авиран гарахыг хориглоно.
- 3.4. Объектод үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан үед түргэн тусламж, галын болон осол аваарын дуудлагаар ирсэн автомашинууд, цагдаагийн албаны автомашинуудыг объектод шууд нэвтрүүлэх.

Дөрөв: Шалган нэвтрүүлэгч харуулчны эрх, үүрэг, хориглох зүйл

- 4.1. Шалган нэвтрүүлэгч харуулчин нь албан үүргээ гүйцэтгэхдээ дор дурдсан эрх эдэлнэ:
- 4.1.1.Объектод нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх бичиг баримтыг шалгахдаа дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- а/үнэмлэх, бичиг баримтыг хавтаснаас нь салгуулан авч үзэх;
 - б/үнэмлэх, баримт бичгийн зураг, бичвэр зөв эсэх, хугацаа, тамга, гарын үсэг зэргийг шалган үзэж, нягтлах;
 - в/хяналтын асуулт асууж, хариулт нь баримт бичигт бичигдсэнтэй тохирч байгаа эсэхийг шалгах, тухайн бичиг баримт үзүүлэгчийн биеэ авч яваа байдал, үйл хөдлөлийг ажиглаж, сэжигтэй үйлдэл гаргаж байгаа эсэхийг дүгнэж, шийдвэр гаргах;
 - г/зөрчлийг илрүүлж, таслан зогсоох.
- 4.1.2.Объектод нэвтрэн орох хүмүүсийн ачаа тээшинд үзлэг хийхдээ дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- а/ ачаа тээшний эзнийг байлцуулан үзлэг хийх;
 - б/ ачаа тээшинд байгаа эд зүйлсийн тоо ширхэг, төрөл, нэрсийг жагсаалтын дагуу шалгах.
- 4.2.Шалган нэвтрүүлэгч харуулчны хүлээх үүрэг
- 4.2.1. Объектод нэвтрэх эрхийн баримт бичгийн загвар, тамга, тэмдэг, гарын үсгийг тогтоох.
- 4.2.2. Хүн, тээврийн хэрэгсэл, ачаа, тээшийг нэвтрүүлэх тогтоосон журмыг чанд сахиулах.
- 4.2.3. Зөрчил гарсан үед хамгаалж байгаа объектод хүн, тээврийн хэрэгслийг зөвхөн салбарын захирагчийн зөвшөөрлөөр нэвтрүүлэх.
- 4.2.4. Нэвтэрч байгаа хүн бүрийн баримт бичгийг нарийвчлан шалгасны дараа нэвтэрхийг зөвшөөрөх.
- 4.2.5. Иргэдтэй соёлтой харьцах, албаныхаа шаардлагыг дүрмийн дагуу тавих.
- 4.2.6. Тээврийн хэрэгслийн “Зогс” тэмдэг бүхий шугам дээр зогсоож, жолоочийг хөдөлнүүрээ унтраасны дараа баримт бичгийг нь шалгах, тээврийн хэрэгсэлд үзлэг хий.

4.2.7. Ачаа, тээшийг дагалдах бичиг баримтад заасан тоо хэмжээтэй нь тохирч байгааг шалгах,

4.2.8. Хүн, тээврийн хэрэгслийг шалгах явцад зөрчил илэрвэл түр саатуулан салбарын захирагч, харуулын дарга нарт нэн даруй илтгэх.

4.3. Шалган нэвтрүүлэгч харуулчны үйл ажиллагаанд хориглох зүйлс:

4.3.1. Хамгаалж байгаа объект, ажлын байрны талаар болон албаны нууцыг бусдад мэдээлэх, ярих;

4.3.2. Зэвсэг тусгай хэрэгслийг биенээсээ салгах;

4.3.3. Ямар ч тохиолдолд бусдыг биедээ хүргэх, хүрэхээр зайд ойртуулах;

4.3.4. Харуулын цэгийн байранд гадны хүн оруулах;

4.3.5. Согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах, хордуулах бодис хэрэглэх;

4.3.6. Үүрэг гүйцэтгэх үедээ унтах, ном унших;

4.3.7. Ажлын цагаар объектын ажилтнуудтай албаны бус харьцаа тогтоох, албан бус үг хэллэгээр харилцах;

4.3.8. Албан үүрэг гүйцэтгэхээс бусад үед объект дотор сэлгүүцэх;

4.3.9. Дүрэмт хувцас, хэрэглэлийг бүрэн бус өмсөж хэрэглэх;

4.3.10. Бусдаас эд зүйл авах, бусдад дамжуулах, зуучлах;


4.3.11. Бусдад соёлгүй, сул дорой, хариуцлагагүй байдал үзүүлэх;

4.3.12. Ажлын байранд тамхи татах.

Энэхүү журмыг зөрчсөн цэргийн алба хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар зарлигаар батлагдсан Цэргийн нийтлэг дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Иргэнд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу арга хэмжээ авна.


БОЛОВСРУУЛСАН:

ХАМГААЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУСГАЙ
САЛБАРЫН ЗАХИРАГЧ, ХОШУУЧ
 С. ТҮВШИНЖАРГАЛ

2023 оны 03-р сарын 01-ны өдөр

ХАМГААЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДАРХАН-УС СУВАГ ХК-НИЙ ДЭД
ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
 Т. БУЯНДЭЛГЭР

2023 оны 03-р сарын 09-ны өдөр

ДАРХАН-УС СУВАГ ХК-НИЙ
САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН
ДАРГА, ЕРӨНХИЙ НЯГТЛАН
 Д. УРАНЧИМЭГ
2023 оны 03-р сарын 09-ны өдөр